



**ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 35

Хэрлэн сум

**Төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион
байгуулах салбар комисс томилох тухай**

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.2.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6, 3.5, 3.5.3, 2023 оны “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, загвар батлах тухай” 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 6.1, 6.5-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.2024 оны 1-р улирлын төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулах салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

| | | |
|------------------------|---------------|---|
| Салбар комиссын дарга: | Ч.Баярцолмон | Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга |
| Нарийн бичгийн дарга: | Ж.Саруултөгс | Салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга |
| Гишүүд: | Г.Лхагвахатан | Салбар зөвлөлийн гишүүн, Орон нутгийн өмчийн газрын дарга |
| | Г.Сэдэдмаа | Салбар зөвлөлийн гишүүн, Статисткийн хэлтсийн дарга |
| | Д.Ганболд | Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн албаны ахмад ажилтан |

2.Салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллах туслах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Төрийн албаны ерөнхий шалгалтыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж, дүнг танилцуулахыг салбар комиссын бүрэлдэхүүнд даалгасугай.


4.Төрийн албаны ерөнхий шалгалтын тайланг хугацаанд нь Төв комисст хүргүүлэхийг Нарийн бичгийн дарга (Ж.Саруултөгс)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн
2024 оны ...⁰³... дугаар сарын ...⁰⁷...-ны өдрийн
...³⁷... дугаар тогтоолын хавсралт



ТУСЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын төлөөлөл
2. Онцгой байдлын газрын төлөөлөл
3. Цагдаагийн газрын төлөөлөл
4. Улсын бүртгэлийн хэлтсийн төлөөлөл
5. Тагнуулын хэлтсийн төлөөлөл
6. Эрүүл мэндийн газрын төлөөлөл
7. БЗӨБЦТС салбарын төлөөлөл